



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 04 сарын 23 өдөр

Дугаар 126

Улаанбаатар хот

“Хөдөө аж ахуйн биржийн арилжааны
зуучлагч /брокер/-аас төвлөрүүлэх зохицуулалтын
үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох” тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.5 дахь заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагчид /брокер/-аас төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 69 дүгээр тогтоолын 3 дахь заалт болон Хорооны 2013 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 155, 2013 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 181 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэхүү тогтоолыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /ХААБ/-дын удирдлагад үүрэг болгосугай.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000128

**ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖИЙН АРИЛЖААНЫ ЗУУЧЛАГЧ /БРОКЕР/-ААС
ТӨВЛӨРҮҮЛЭХ ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСНИЙ ХЭМЖЭЭ**

д/д	Зохицуулалтын үйлчилгээний хөлсөд хамаарах тусгай зөвшөөрлийн харилцаа	Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ /төгрөгөөр/	Нэмэлт мэдээлэл	Төвлөрүүлэх хугацаа
1.	Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлал /брокер/-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох	100,000	Анх удаа тусгай зөвшөөрөл авах болон тусгай зөвшөөрлийн нөхцөл өөрчлөхөд тус тус хамаарна	Шийдвэр гарснаас хойш ажлын 4 өдрийн дотор
2.	Тусгай зөвшөөрөл сунгах	100,000		
3.	Бараа, түүхий эдийн нэр төрлөөр тусгай зөвшөөрөл нэмж олгох	50,000		
4.	Арилжих гэрээний нэр төрлөөр тусгай зөвшөөрөл нэмж олгох	100,000		
5.	Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц, хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах	100,000		
6.	Нэр өөрчлөх	2,000,000		
7.	Салбар нээх	100,000		
8.	Тусгай зөвшөөрөл сэргээх	50,000		
9.	Үрэгдүүлсэн, гэмтээсэн гэрчилгээг нөхөж олгох	200,000	Тухай бүр	Ажлын 1 өдрийн дотор
10.	Баримт бичиг хуулбарлан өгөх	1,000 /нүүр тус бүрээс/		
11.	Хөдөө аж ахуйн /ХАА-н/ биржийн арилжааны зуучлал /брокер/-ын үйл ажиллагаанаас төвлөрүүлэх	ХАА-н биржээр арилжаалагдсан худалдах, худалдан авах гэрээний нийт үнийн дүнгийн 0.08 хувь	Хийсэн арилжааны үнийн дүнгээс хамаарна	Арилжаа хийгдсэнээс хойш ажлын 10 өдрийн дотор